

**“МОНИНЖБАР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Улаанбаатар хот

2015 оны 4-р сарын 17

Хурал “Монинжбар” ХК – ийн хурлын танхимд 15:30 цагт эхлэж, 19:10 дуусав.

Хурлаар хэлэлцэх асуудлууд

1. 2014 оны компанийн үйл ажиллагааны тайлан
2. 2014 оны санхүүгийн тайлан
3. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох
4. Ногдол ашгийн тухай
5. 2015 оны төлөвлөгөө

Хурлын дэг

Хурлын ирцийг бүртгэх /ажлын хэсэг/	15.00-15.20
Тооллогын комиссыг сонгож батлах	10 минут
Хурлын ирцийг мэдээлэх	5 минут
Хурлын даргыг сонгож батлах	5 минут
Хурлын дарга хурлыг нээж үг хэлэх	5 минут
Гүйцэтгэх удирдлагын 2014 оны ажлын тайлан	10 минут
2014 оны санхүүгийн тайлан	10 минут
ТУЗ-ийн гишүүдийг сонгох	30 минут
Ногдол ашгийн тухай	10 минут
Компанийн 2015 оны зорилтыг танилцуулах	10 минут
Хувь нийлүүлэгчидээс үг хэлэх, санал гаргах /1 хүнд/	5 минут
Хурлын тогтоолыг танилцуулж, хурлыг хаах	10 минут

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Баярсайхан хурлын дэгийг танилцууллаа.

Б.Баярсайхан: Хурлын дэгийн дагуу тооллогын комиссыг томилё. Тооллогын комиссын бүрэлдэхүүнд саналаараа орох хувьцаа эзэмшигчид байна уу?

Б.Мянганбаяр: Тооллогын комиссын бүрэлдэхүүнд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Энхчулуун, гүйцэтгэх захирлын нарийн бичиг Б.Үүрцайх нарыг сонгох саналтай байна.

Б.Баярсайхан: Өөр саналтай гишүүд байна уу... байхгүй бол тооллогын комиссын бүрэлдэхүүнээр Н.Энхчулуун, Б.Үүрцайх нарыг сонгох саналаа өгнө үү.

Гишүүд татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй 100 хувь зөвшөөрсөн тул ХНХ-ын тооллогын комиссоор Н.Энхчулуун, Б.Үүрцайх нарыг, комиссын даргаар Н.Энхчулууныг сонголоо.

Тооллогын комисс саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хийж хурлын даргад танилцуулна уу.

Б.Баярсайхан: Компанийн хувь нийлүүлэгчдийн энэ удаагийн ээлжит хуралд компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс төлөөлж н.Андсайхан ажиглагчаар оролцож байна.

Мөн 2015 оны 02 сарын 13-ны өдөр ТУЗ-ийн 02 тоот тогтоолоор ТУЗ-ийн дарга байсан Б.Нарантуяа нь өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөж, ТУЗ-ийн даргаар түр хугацаанд томилогдсон Б.Пүрэв-Очир оролцож байна.

Н.Энхчулуун: /Саналын эрхтэй хувьцааг тоолов/ Хувь нийлүүлэгчдийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцааг тоолоход

- Итгэмжлэлээр оролцож байгаа 6 хүн
- Би Ди Сек БДК-д итгэмжлэсэн 1 хүн
- Би Ди Сек БДК-ийг төлөөлөн оролцож буй 1 хүн
- Биеэр ирж оролцож буй 4 хүн байна.

2015 оны 03 сарын 03-ны өдрийн ҮЦТТХТ-өөс гаргасан тус компанийн хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаагаар 299 иргэн 15 869 233 ширхэг хувьцааг эзэмшдэгээс хуралд 12 252 459 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид оролцож байна. Үүнийг хувиар авч үзвэл 77,2 хувийн ирцтэй байна. Энэ нь компанийн дүрмийн 7.4-т "Хувьцаа эзэмшигчдийн хурал нь саналын эрхтэй нийт хувьцааны 70-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч буюу тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцсоноор хүчин төгөлдөр болно. Санал авах хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсонд тооцно." гэж заасныг хангаж байгаа тул хурлыг хүчин төгөлдөр гэж үзэж хурлыг эхлүүлэхийг зөвшөөрч байна.

Б.Баярсайхан: Монгол улсын компанийн тухай хууль болон компанийн дүрмэнд заасны дагуу нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 77,2 хувь нь хуралд оролцож байгаа тул хурлыг хүчин төгөлдөрт тооцсон тооллогын комиссын тогтоолыг батлах уу?

Татгалзсан, түдгэлзсэн гишүүд байхгүй тул тогтоолын төслийг 100 хувийн саналаар баталлаа.

Б.Баярсайхан: Хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн хурлын даргыг сонгох ёстой тул гишүүд хурлын даргаар сонгох оролцогчийг нэр дэвшүүлнэ үү.

Г.Гансүх: Хурлын даргаар хурал зохион байгуулах комиссын дарга Б.Баярсайханыг сонгох саналтай байна.

Б.Баярсайхан: Өөр саналтай гишүүд байна уу?

Гишүүдээс өөр санал ирээгүй тул хурлын даргаар Б.Баярсайханыг сонгох саналтай гишүүд гараа өргөнө үү. Гишүүдийн 100 хувийн саналаар Б.Баярсайханыг сонголоо.

Хурлын дарга: Юуны өмнө эрхэм хувьцаа эзэмшигчид болон хөндлөнгөөс хяналт тавин оролцож байгаа та бүхнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэнд талархаж байна.

Та бүхнийг хурлын үйл ажиллагаанд идэвхитэй оролцож нээлттэй ярилцана гэдэгт итгэлтэй байна. Ингээд хурлын үйл ажиллагаа нээснийг мэдэгдэе!

Бид бүх гишүүдийн хурлын материалыг и-мэйл болон зарим брокер диллерийн компаниудад шуудангаар хүргэж өгсөн байгаа. Нийт 27 БДК-нд материал тараасны 9 нь шуудангаар хүлээж авсан байгаа. Иймд та бүхнийг хурлын материалтай хангалттай танилцсан гэж үзээд хурлын дэгийн дагуу 2014 оны компанийн үйл ажиллагааны тайланг сонсож хэлэлцье. Гүйцэтгэх заахирлыг индэрт урьж байна.

Гүйцэтгэх захирал компанийн 2014 оны үйл ажиллагааны талаар илтгэл тавилаа.

Компанийн 2014 оны тайлангийн талаар асуух, тодруулах зүйл байвал та бүхэнтэй нээлттэй илэн далангүй харилцан ярилцах саналтай байна.

С.Мягмарсүрэн: Надад нэг санал байна. Компанийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаар илтгэлийг нэг мөр сонссоны дараа асуулт хариулт руу орвол яасан юм бэ?

Хурлын дарга: Мягмарсүрэнгийн саналыг дэмжих үү... дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 100 хувь санал дэмжигдсэн тул компанийн 2014 оны санхүүгийн тайланг сонсьё. Илтгэлийг компанийн ерөнхий санхүүч тавина.

Санхүүгийн тайланг товч танилцууллаа.

Хурлын дарга: За одоо асуулт хариулт руугаа оръё.

С.Мягмарсүрэн: Элэгдэлээ яг яаж тооцдог вэ? Шулуун шугамын аргаар тооцдоггүй юмуу энэ чинь хааяа болохоор 100%-иар тооцоод хааяа багаар тооцдог гэсэн. Яагаад ийм байна.

Г.Өлзийсайхан: Тийм зарим улиралд тооцохгүй байгаа. Ерөнхийдөө шулуун шугамын аргаар тооцож байгаа. Компани 1,2-р улиралд орлогогүй, дандаа зардал гардаг учраас энэ улирлуудад элэгдлийг багаар тооцож байгаа.

С.Мягмарсүрэн: Тооцохгүй бол санхүүгийн тухай хуулийн олон улсын стандартын хууль зөрчсөн ч юмуу тийм юм болохгүй юу? Зүгээр үү?

Г.Өлзийсайхан: Зүгээр. Бид нар зарим нэг улиралдаа тооцдоггүй. Тэгээд жилийн эцэст тооцно. Яагаад гэхээр зарим 1, 2 улиралдаа барилга угсралтын ажил явагдаагүй, орлого байхгүй, дан зарлага гарчихдаг. Тэрэнтэйгээ уялдуулаад үндсэн хөрөнгө элэгдүүлээд байхгүй. Барилгын ажилтай холбоотойгоор тооцохгүй үе байна.

П.Бүрнээбаатар: Элэгдэл гэж яг юуг тооцоод байна.

Г.Өлзийсайхан: Үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж, машин механизмийн ашиглалтаас шалтгаалаад мэдээж анхны байсан байдлаас мууддаг. Үүнийг Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу тухайн хөрөнгийн үнэлгээг хорогдуулж явдаг.

Ц.Оргилболд: Компанийн ашиг төлөвлөж байснаас багассан байна. Ямар шалтгаантай гэж үзэж байна.

Гүйцэтгэх захирал Б.Баярсайхан: Бид 2014 оны цэвэр ашгийг 600 орчим сая төгрөгийн ашигтай байх болов уу гэж тооцож байсан. Энэ нь дараах үндсэн шалтгаануудтай гэж үзэж байгаа.

- 2014 - 2015 онд хэрэгжих байсан “5в” төсөл дээр өндөр зардал гаргасан. Энэ юу вэ гэхээр Эрчим хүчний яам буюу захиалагчаас танайх санхүүгийн боломжтой бол энэ ондоо багтаад дуусгаад өгчих. Яагаад гэхээр тэнд нь ашиглагдаж байсан дулааны шугамыг буулгасан, 09 сарын 15-нд хэрэглэгчдийг холбох шаардлагатай болдог. Тиймээс гэрээт ажлыг 100% дуусгаж байнгын ашиглалтанд хүлээлгэж өгөхийн тулд дутагдаж байгаа хөрөнгийг Хаан банкны 1,8 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлсэнээс зээлийн хүүгийн зардал өссөн. Би дээр илтгэлдээ уг ажлын санхүүжилт яаж хийгдэх ямар шатандаа яваа талаар дурдсан тул та бүхнийг ойлголттой байгаа гэж үзэж байна.

- Мөн тухайн ажлыг богино хугацаанд гүйцэтгэхийн тулд техникийн болон хүн хүчийг ихээр ашиглаж түүнтэй холбоотой цалингийн болон түрээсийн зардлууд нэмэгдсэн.

- Тендер шалгаруулалтын үеийн валютын ханш болон импортоор худалдан авдаг бараа материалын худалдан авах үеийн ханшийн зөрүү өндөр гарсан.

Эдгээрээс нилээн алдагдал хүлээсэн.

Ер нь бол инженер, техникийн ажилчид он дамжсан ажил гэхээр тайвширчихдаг. Зардал нь автоматаар өсөөд байдаг. Үүнээс сэргийлээд бид ажлыг ер нь богино хугацаанд гүйцэтгэж дуусгавал дээр юм. Санхүүгийн хувьд ч, нэр хүндийн хувьд ч их нөлөөлөл үзүүлдэг гэж үзэж байна.

Та бүхэн мэдэж байгаа байх. Энд дандаа манай хувьцаа эзэмшигчид байна. Тендер авахад хэр их хүчин чармайлт гардаг, хэр их саад бэрхшээл гардаг зэргийг мөн ажил гүйцэтгэх явцад ялангуяа Улаанбаатар хотод нэг байцаагч хүрч ирээд зөвшөөрөл нэхээд ажил зогсоох эсвэл санамсаргүй нэг кабель тасалчихвал бөөн төлбөр нэхдэг гэх мэтчилэн.

Санхүүгийн тайлангаас асуух тодруулах зүйл байна уу. Нээлттэй асууж ярилцана.

П.Бүрнээбаатар: Нэг тодруулах зүйл байна. Түрүүн 2014 онд хийгдсэн ажлаас 2,865 сая төгрөг авах дутуу байна гэсэн энэ нь дандаа яам, төрөөс санхүүжигдэх юмуу?

Б.Баярсайхан: Тийм энэ маань их сонин юм болсон одоо энэ “5В” 2,865 тэрбум дээр Улсын төсвөөр 2015 онд санхүүжигдэхээр батлагдсан. Гэхдээ 2015 оны 02 сарын 15-нд төсөвт тодотгол хийхдээ 2015 онд ажлаа дууссан 2015 онд санхүүжигдэх төсвүүдийн 50 хувийг автоматаар хассан. Зөвхөн манайх биш бүх 500 саяаас дээш хөрөнгө оруулалттай бүх санхүүжилтүүдийг хассан. 2015 онд 1 432 сая төгрөгөөр санхүүжигдэх болсон. Гэхдээ энэ нь улсын төсвөөр санхүүжигдэхгүй төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр хөгжлийн банкнаас санхүүжигдэнэ гээд батлаад өгчихсөн. Тэгээд одоо 2015 ондоо 1 432,8 сая төгрөгийг авч чадахгүй болсон.

Б.Бүрнээбаатар: Гэрээн дээрээ 2015 онд авна гээд заачихсан байгаа биз дээ. Гэрээнд хүлээх үүрэг хариуцлага гэж байгаа биз дээ.

Б.Баярсайхан: Гэрээний алданги дээрээ 0,3 хувь гэж байгаа. Тэгээд энийгээ Хөгжлийн банкнаас санхүүжүүлнэ гэчихсэн байгаа.

Энэ жил бид 1 432,8 сая төгрөг авах хэрэгтэй болчихоод байна. Хэрвээ бид уг нь 1 сард санхүүжилтээ авсан бол 6 сарын хүүнээс чөлөөлөгдөх байсан. Энэ нь нийтдээ сард 30 сая төгрөгийн хүү төлж байгаа гэж тооцоход 6 сард нийт 180 орчим сая төгрөгийн хүү төлж байна. Эндээс харахад олсон ашгаа санхүүжилт хийгдэхгүйн улмаас өөрөөр хэлбэл төр үүргээ биелүүлэхгүй байгаагийн улмаас зээлийн нэмэлт хүү гарч төлөхөөр харагдаж байна.

С.Мягмарсүрэн: Гэрээн дээрээ санхүүжилт хоцроовол энэ тэр гэсэн заалт байхгүй юмуу?

Б.Баярсайхан: Тийм заалт байгаа. Гэрээнийхээ ерөнхий нөхцөл дээр ч байгаа, хүлээх үүрэг дээрээ ч байгаа. Санхүүжилт хоцроовол 0,03 хувийн алданги тооцохоор байдаг. Гэхдээ хэзээ ч улс тэрийгээ төлж байсан түүх байхгүй. Мөн гүйцэтгэлийн санхүүжилтийг батлагдсан өдрөөс хойш 21 хоногийн дотор шийдвэрлэнэ гэсэн заалт байдаг.

Одоогоор Улсын төсвөөс 200 гаруй компани санхүүжилтээ авч чадахгүй байгаа судалгаа байна. Үүнээс 2, 3 компани шүүхээр шийдвэрлүүлэх гээд явсаар байгаад шүүхийн шийдвэр гарчихсан байхад хүртэл мөнгөө авч чадсан газар байхгүй. Яагаад гэхээр улс мөнгө байхгүй гээд таг болчихдог.

Манай нийгэм ахуйн барилгын холбоонд инженерийн шугам сүлжээний угсралтын 180 гаруй компани нэгдсэн байдаг. Үүнээс энэ жил 80 орчим компани л үйл ажиллагаа явуулах боломжтой байна гэж байна. Яагаад гэхээр татварын өртэй, зээлийн өртэй гээд үйл ажиллагаа явуулах боломжгүй болчихсон.

2015 онд ер нь иймэрхүү хүндрэлтэй асуудлууд байгаа. Улсын төсвийн орлого бүрдүүлэлт байнга тасалдаж байгаагаас шалтгаалж төсвөөс санхүүжигдэх тендерүүд өнөөг хүртэл зарлагдаагүй байна. Одоогийн байдлаар 1 тендерт орчихсон байгаа. Цаашид 4 тендерт орохоор бэлдчихсэн байгаа. Тэгээд бэлтгэл ажил татан авалт гэсээр байгаад бараг наадмаар барилга угсралтын ажил эхлэх байх. Тэгэхээр энэ жил нилээн оройтож ажил эхлэх болоод байна. Одоо уг нь материалдаа явж байдаг үе. Тэгэхээр 2015 он маань нилээн чанга жил болж магадгүй.

Санхүүтэй холбоотой асуух зүйл байна уу?

II.Бүрнээбаатар: Ер нь 2015 оны санхүүгийн зорилт гэж байгаа юу мэдээлэл гаргасан уу?

Б.Баярсайхан: ТУЗ-ийн гишүүдийг сонгосны дараа компанийн 2015 оны зорилт төлөвлөгөөг хэлэлцэхээр хурлын дэгт тусгагдсан байгаа. Гэвч нэгэнт компанийн 2014 - 2015 оны үйл ажиллагааны талаар ярилцаж байгаа тул шууд үргэлжлүүлээд яриад явчих уу? Дараа нь ТУЗ-ийн гишүүдээ сонгоё.

С.Мягмарсүрэн: Тэр нь дээр байхаа

Хурлын дарга: Гишүүд зөвшөөрч байгаа бол гүйцэтгэх удирдлагыг компанийн 2015 оны зорилт төлөвлөгөөг танилцуулахыг хүсье.

Компанийн 2015 оны зорилт төлөвлөгөөг танилцуулав.

Хурлийн дарга: Компанийн 2015 оны зорилт төлөвлөгөөтэй холбоотой асуулт, хариулт байна уу, хамгийн гол нь санал байна уу?

II.Бүрнээбаатар: Би хамгийн гол нь 2015 он бол хөдөлмөр аюулгүй ажиллагааны жил болгон зарлаж байгаад талархаж байна. Энэ нь ажилчдын хөдөлмөр аюулгүй ажиллагаа, осол аюулгүй байх тал дээр сайн сургах хэрэгтэй, хүмүүсийг хайрлах, ялангуяа аюулгүй ажиллагаан дээр мөнгө харамлаж болохгүй. би өөрөө дулааны инженер, янз бүрийн асуудлууд гарч байдаг болохоор би сайн ойлгож байна.

Б.Баярсайхан: Үүнийг бол гүйцэтгэх удирдлагын зүгээс анхаарч ажиллаж байгаа. Бурханы ивээлээр одоогийн байдлаар янз бүрийн асуудал гараагүй байгаа. Энэ асуудал дээр хариуцлагатай ажиллаж болж өгвөл Оюу толгой, Энержи Ресурсын хэмжээнд ажиллахаар чармайж байгаа.

Өөр асуудал байна уу?

Ц.Чимгээ: Би анх удаа танай компанийн хуралд оролцож байна. Хурлын явцаас харахад хурлын дэгээ баримталсан харилцан нээлттэй ярилцсан, бүлээн дулаан уур амьсгалтай

болдог юм байна. Надад компаниас гарч байгаа хурлын шийдвэр, танилцуулга, илтгэлийн талаарх персантаци авч болохуу?

Ер нь мэдээллүүдээ өөрийн веб хуудсан дээр сайн тавьж баймаар байна. Би танай компанийг яг ямар үйл ажиллагаа явуулдаг талаар мэдээлэлгүй орж ирсэн.

Б.Баярсайхан: Манай веб хуудас уг нь байгаа. Манай веб хуудсыг ажиллуулдаг байсан нарийн бичиг маань амаржаад одоогоор ажиллуулах хүнгүй байгаа. Саяхан шинэ нарийн бичиг авсан удахгүй ажилд оруулна. Цаг тухайн үедээ мэдээллүүдээ оруулаад явна.

Өөр асуудал байна уу?

С.Мягмарсүрэн: Тайланг сонслоо. Ашиг нь одоохондоо бага байгаа ч гэсэн яваандаа нэмэгдэнэ гэж бодож байгаа. Та бүхнийг сайн ажиллаж байгаад баярлалаа. Мөн түрүүний ярьсан тэр барилга бариулах гэж байгаа гэдэг чинь маш зөв. Ийм ажил эхлүүлж байгаад талархаж байна.

Харин аж ахуйн газрыг нисэхийн тийшээ хурдны зам тааруулаад ч юмуу автобас зүгээр санагдсан.

Б.Баярсайхан: За баярлалаа. Өөр асуулт, санал байхгүй бол энэ санхүүгийн тайлан, төлөвлөгөөг хэлэлцэх асуудлыг хааж байна.

Хурлын дарга: Хурлын дэгийн дагуу дараагийн асуудал нь компанийн ТУЗ-ийг сонгох байгаа. Компанийн дүрмэнд ТУЗ-ийн гишүүдийг 3 жилийн хугацаатайгаар сонгодог. Энэ жил ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа дуусч байгаа. Одоо энэ жил дахин сонгох шаардлагатай болж байна. Компанийн дүрмээр ТУЗ-ийн нэр дэвшүүлэх дэд хорооны дарга нь ТУЗ-ийн дарга байдаг. Ингээд ТУЗ-ийн дарга Б.Пүрэв-Очирт микрофон шилжүүлье.

Б.Пүрэв-Очир: Сайн байцгаана уу! Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол улсын компанийн тухай хууль болон компанийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан журамд ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо кумулятив аргыг хэрэглэх талаар тодорхой заасан байдаг. Энэ талаар манай гишүүд хангалттай мэдээлэлтэй байгаа гэж үзээд ТУЗ-д нэр дэвшигчдийг танилцуулья.

Хуулийн дагуу компанийн хувьцааны 5 хувиас дээш хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй. Компанийн хувьцааны тархалтын мэдээллээс харахад нэр дэвшүүлэх эрхтэй 4 төлөөлөл байна.

1. Ц.Оргилболд
2. Б.Цогтгэрэл
3. Ц.Чингүүнболд
4. Fang investment S.A.R.L

Компанийн дүрмийн 8,2 –т зааснаар ТУЗ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба үүний 1/3-ээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

Одоо ажиллаж байгаа ТУЗ-ийн гишүүдийн 3 нь ердийн гишүүн, 6 нь хараат бус гишүүд ажиллаж байсан. Иймээс бид хараат бус гишүүний тоон дээр ярилцаад баталгаажуулан цааш үргэлжлүүлбэл зүгээр байх. ТУЗ-өөс 9 гишүүний 5 нь ердийн 4 нь хараат бус гишүүн байхаар санал оруулж байна.

Хурлын дарга: ТУЗ-өөс оруулж байгаа саналаас өөр саналтай гишүүд байвал саналаа хэлнэ үү. /Өөр саналтай гишүүн байсангүй/ Өөр саналтай гишүүн байхгүй бол ТУЗ-өөс оруулж байгаа саналыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. 100 хувийн саналаар дэмжлээ. Нэр дэвшүүлэх хорооны даргыг цааш үргэлжлүүлэхийг хүсч байна.

Б.Пүрэв-Очир: ТУЗ-д нэр дэвшиж байгаа хүмүүсийг танилцуулья.

1. Ц.Оргилболд	ердийн гишүүн
2. Б.Баярсайхан	ердийн гишүүн
3. С.Баярцэцэг	ердийн гишүүн
4. Г.Өлзийсайхан	ердийн гишүүн
5. Ш.Алтанцэцэг	ердийн гишүүн
6. Б.Пүрэвбаатар	ердийн гишүүн
7. Б.Пүрэв-Очир	Хараат бус гишүүн
8. З.Азжаргал	Хараат бус гишүүн
9. Б.Баттөмөр	Хараат бус гишүүн
10. Я.Батцэцэг	Хараат бус гишүүн

Б.Баярсайхан: Компанийн дүрмэн дээр ТУЗ-ийн гишүүнийг кумулятив аргаар сонгоно гэж заасан байдаг. Зарим нэг хувьцаа эзэмшигчдийг бас сайн мэдэхгүй байгаа боловуу гээд компанийн засаглалийн үндэсний зөвлөлийн төлөөлөл н.Андсайхан таныг тайлбарлаж өгнө үү гэж урьж байна.

н.Андсайхан: Одоо ердийн гишүүн 5 хүнийг сонгохын тулд өөрийнхөө эзэмшиж байгаа хувьцааг 5-аар үржүүлээд тэр 5 хүндээ саналаа хувааж өгнө. Гэхдээ 1 хүнд бүгдийг нь өгч болно эсвэл 2 хүнд ч юмуу 3 хүнд хувааж өгч болно. Тэр 5-аар үржүүлсэн тоотой нийт өгсөн саналын тоо чинь тэнцэж байх ёстой. Хэрвээ тэнцэхгүй бол хүчингүй болно гэж үздэг. Тийм учраас тэрийгээ сайн бодож гаргах хэрэгтэй. Хараат бус дээрээ 4 хүн сонгох гэж байгаа учраас эзэмшиж байгаа хувьцаагаа 4-өөр үржүүлээд мөн адил хувааж өгнө. Дүн нь мөн нийлбэртэйгээ таарч байх ёстой.

Хурлийн дарга: За баярлалаа. Одоо хувьцаа эзэмшигчид та бүхэнд ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох саналын хуудсыг тараасан байгаа. Та саналын хуудсаа бөглөж тооллогын комиссын гишүүдэд өгнө үү.

Тооллогын комисс саналын хуудсыг нэгтгэж үр дүнг танилцуулахыг хүсье. /Гишүүд саналын хуудсыг бөглөж нэгтгэн тоолж, тогтоолын төслийг бэлтгэх хугацаа 30 мин үргэлжлэв./

Хурлын дарга: Тооллогын комисс саналыг нэгтгэсэн бол танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Н.Энхчулуун: ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшиж байгаа хүмүүст өгсөн саналын хуудсыг тоолж хамгийн их санал авсан дараах хүмүүсийг компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр сонгох саналыг оруулж байна.

1. Ц.Оргилболд	ердийн гишүүн
2. Б.Баярсайхан	ердийн гишүүн
3. С.Баярцэцэг	ердийн гишүүн
4. Г.Өлзийсайхан	ердийн гишүүн
5. Б.Пүрэвбаатар	ердийн гишүүн
6. Б.Пүрэв-Очир	Хараат бус гишүүн
7. З.Азжаргал	Хараат бус гишүүн
8. Б.Баттөмөр	Хараат бус гишүүн
9. Я.Батцэцэг	Хараат бус гишүүн

Хурлын дарга: Дараах хамгийн их санал авсан нэр дэвшигчдийг компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр сонгох саналыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү. /100 хувийн саналаар санал дэмжигдлээ./

Хурлын дарга: ТУЗ-ийн гишүүдээр сонгогдсон хүмүүсдээ баяр хүргэе. Та бүхнийг компанийн гүйцэтгэх удирдлагыг дэмжиж цаг үеийн яаралтай шийдвэрлэх асуудлыг хугацаа алдалгүй шийдвэрлэж хамтран ажиллана гэдэгт найдаж байна.

Одоо хурлын дэгийн дагуу ноогдол ашгийн талаар ТУЗ-өөс гарсан шийдвэрийг танилцуулья.

Компанийн ТУЗ-ийн 2014 оны 02 сарын 07-ны өдрийн тогтоолыг хэлэлцэж 100 хувийн саналаар дэмжлээ.

Хурлын дарга: Та бүхэнд хурлаас гарах тогтоолын төсөл болон шийдвэрүүдийг хурлын нарийн бичгийн дарга Н.Энхчулуун танилцуулна.

Хурлаас гарах тогтоолын төслүүдийг танилцууллаа.

Хурлын дарга: Та бүхэнд хурлаас гарах тогтоолын төслүүдийг танилцууллаа. Татгалзсан, түдгэлзсэн гишүүд байвал саналаа хэлнэ үү. /Татгалзсан санал гарсангүй/

Өөр саналтай гишүүд байхгүй бол тогтоолын төслүүдийг батлах уу. /Тогтоолын төсөл 100 хувийн саналаар батлагдлаа./

Хуралдаа идэвхитэй оролцсонд талархал илэрхийлэе. Та бүхэнд эрүүл энх, ажлын өндөр амжилтыг хүсье!!!

ПРОТОКОЛТОЙ ТАНИЛЦСАН:

Хурлын дарга

Б.Баярсайхан

Хурлын протокол хөтөлсөн:

Б.Үүрцайх